

## **ЭРХТЭН, ЭД, ЭС ШИЛЖҮҮЛЭН СУУЛГАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

**Нэг. Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага**

### **1.1. Хууль зүйн үндэслэл, шаардлага**

Монгол Улсын Үндсэн Хуулийн Арван зургадугаар зүйлд “Монгол Улсын иргэн амьд явах, эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусlamж авах...” эрхтэй гэж заасан. Нэгдсэн Үндэсний Байгууллагын ерөнхий ассамблейгаас баталсан Дэлхийн тогтвортой хөгжлийн зорилтын 3-д нийгмийн эрүүл мэндийн бүх нийтээр хамралтад хүрэх зорилтыг тодорхойлж, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас хүний эрхийг хангахын тулд эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээнд хэнийг ч орхигдуулахгүй байх зарчмыг гишүүн орнууддаа зөвлөсөн.

Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын (ДЭМБ) 2010 оны 5 дугаар сард хуралдсан 63 дугаар чуулганаар “Resolution WHO 63.22” шийдвэрийг баталсан. Энэхүү шийдвэрийн хүрээнд Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээ үйлчилгээг баримталж ажиллах 11 заалт бүхий зарчмуудыг тодорхойлсон бөгөөд энэ зарчмуудыг үйл ажиллагаанд мөрдлөг болгон хэрэгжүүлэн ажиллахыг гишүүн орнууддаа зөвлөмж болгосон.

Мөн УИХ-ын 2021 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай 12 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах зорилготой болно.

Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал - 2030-д зонхилон тохиолдох халдварт бус өвчин, тэдгээрийн эрсдэлт хүчин зүйлийн тархалт болон сэргийлж болох нас барагтыг хувь хүн, гэр бүл, хамт олон, байгууллагын идэвхтэй, оролцоотой нэгдмэл үйл ажиллагаанд тулгуурлан бууруулах гэсэн зорилт дэвшүүлсэн. Мөн Монгол Улсын Засгийн Газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, МУ-ын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлал “Алсын хараа 2050” болон ЗГ-аас 2017 онд баталсан 24 дүгээр тогтоолд “Эрүүл мэндийн асуудлыг бусад салбарын бодлогод тусган уялдуулж, нэгдсэн зохицуулалттайгаар хэрэгжүүлэх механизмыг бүрдүүлснээр хүн амын эрүүл, аюулгүй орчинд ажиллаж, амьдрах нөхцөлийг сайжруулах” зорилтыг тус тус тодорхойлсон.

Түүнчлэн Монгол Улсад Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээ үйлчилгээг зохицуулах биеэ даасан хууль өнөөг хүртэл байгаагүй болно. Эдгээр

бодлогын зорилтуудыг хэрэгжүүлэхэд хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох хүрээнд хуулийн төслийг боловсруулах хэрэгцээ шаардлага гарсан болно.

## 1.2.Практик үндэслэл, шаардлага

Анх Донорын тухай хууль 2000 онд батлагдсан бөгөөд тус хууль нь цусны донорын үйл ажиллагааг зохицуулж байгаа бөгөөд эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулж буй цөөн хэдэн заалт орсон байдаг. Монгол Улсын Их Хурлаас “Донорын тухай” хуулийн шинэчилсэн найруулгын төслийг 2018 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр баталж одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хэдий ч өнөөгийн цаг үеийн шаардлагыг бүрэн хангахгүй болсон. Цусны донорын үйл ажиллагааны зохицуулалтын хуулинд Эрхтэн, эд, эсийн эмчилгээний зарим зохицуулалтыг хавсаргаж оруулсан. Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээний онцлог, мэргэжил тус бүрийн нарийн төвөгтэй олон асуудлууд зохицуулагдаагүй орхигдсон буюу “Донорын тухай” хуулийн нэмэлт өөрчлөлтийг боловсруулах явцад энэ бүх асуудлуудыг нэмэлт өөрчлөлтөд багтаан оруулах боломжгүй байсан. Иймд эдгээр олон асуудлуудыг зохицуулах, эрх зүйн орчныг бүрдүүлэх, бие даасан хууль боловсруулан гаргах нь практик, үйл ажиллагааны явцад зайлшгүй хэрэгцээ шаардлага бий болсон.

Дэлхийн 93 улс оронд эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээ үйлчилгээг ямар нэг хэмжээгээр хийж гүйцэтгэж байгаа бөгөөд эдгээрээс 90 оронд эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээний тухай биеэ даасан хууль тогтоомж байдаг байна. Монгол улс нь хөгжиж буй орон бөгөөд эдийн засаг , санхүүгийн хувьд хязгаарлагдмал бололцоотой хэдий ч энэхүү эмчилгээний төрлүүдийг хамтад нь амжилттай хийж гүйцэтгэж байгаа цөөн орны тоонд багтдаг.

Монгол улсад эрхтэн шилжүүлэн суулгах мэс заслын эмчилгээ эрчимтэй хөгжиж 2006 онд анхны бөөр шилжүүлэн суулгах мэс заслыг амжилттай хийснээс хойш 2023 оны 12 дугаар сарыг хүртэл Улсын Нэгдүгээр төв эмнэлэгт 331 иргэнд бөөр (41 иргэнд амьгүй донороос бөөр шилжүүлэн суулгасан), 234 иргэнд элэг (12 иргэнд амьгүй донороос элэг шилжүүлэн суулгасан), Хавдар судлалын үндэсний төвд нийт 118 хүнд элэг шилжүүлэн суулгах (эдгээрээс 10 хүнд амьгүй донороос элэг шилжүүлэн суулгасан) тус тус амжилттай шилжүүлэн суулгах эмчилгээг хийсэн байна.

Түүнчлэн эд, эс, үр шилжүүлэн суулгах эмчилгээний төрлүүд хурдацтай хөгжиж иргэдийн амьдралын чанарыг сайжруулах, үр хүүхэдтэй болох хүсэл мөрөөдлийг нь биелүүлж байна. Одоогоор 24 иргэнд ясны чөмөгний үүдэл эс, 24 иргэнд нүдний эвэрлэг, 1735 иргэнд арьс, 150 гаруй иргэнд шөрмөс, 974 иргэнд үр шилжүүлсэн суулгах эмчилгээг хийж 442 амьд хүүхэд төрсөн байна.

Монгол Улсын хүн ам тогтвортой өсөн нэмэгдэж одоо 3.4 сая гаруй болсон бөгөөд хүн амын дунд 45 хүртэлх настай иргэд 2 615 270 буюу хүн амын 70 гаруй хувийг эзэлж байна. Хүн ам тогтвортой өсч, залуучуудын эзлэх хувь өндөр байгаа нь ирээдүйд өвчин эмгэг өсөх хандлагатай байна гэдгийг харуулж байна. Энэ хэрээр эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээ, үйлчилгээний хэрэгцээ шаардлага улам их болно.

Амьгүй донороос эрхтэн, эд шилжүүлэн суулгах эмчилгээг өргөжүүлэн нэг донороос аль болох олон хүнд шинэ амьдрал өгч амьдралын чанарыг нь дээшлүүлэх зорилгоор нойр булчирхай болон зүрх шилжүүлэн суулгах үндэсний багуудыг байгуулан бэлтгэл ажлуудыг ханганд ажиллаж байна.

Үүний зэрэгцээгээр үүдэл эсийг эс, эд нөхөн сэргээх эмчилгээнд ашиглах, эмчлэгдэхгүй байгаа олон төрлийн өвчинүүдийг эмчлэх арга замыг нээх цаашлаад хүйн цус, эс, эдийг хадгалах банк байгуулах эсийг олшруулан урган төлжүүлэх шинэ арга технологи эмчилгээ үйлчилгээний практикт ашиглах, нэвтрүүлэн хөгжүүлэх хэрэгцээ шаардлага амьдрал практикт тулгараад байгаа билээ.

Дэлхийн улс орнуудад эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээ, үйлчилгээ эрчимтэй хөгжиж байгаа бөгөөд энэ төрлийн эмчилгээ нь тухайн эрхтэн, эд, эсийг шинэ эрхтэн, эд, эсээр сольж, нөхөн төлжүүлж өвчнийг бүрэн анагаах, амьдралын чанарыг эрс сайжруулдаг тул улс орон бүр энэ салбарт маш их хөрөнгө, санхүү, хүн хүч зарцуулж байна. Энэ ч утгаараа маш олон төрлийн шинэ судалгаа, туршилтууд хийгдэж эмчилгээний шинэ аргууд нэвтэрч байна.

Гэсэн хэдий ч эмчилгээний арга хөгжихийн хажуугаар сөрөг үр дагавар гарч байгаа бөгөөд түүний эсрэг 2008 онд Турк улсын Станбул хотод дэлхийн 145 орны эрүүл мэндийн сайд нарын уулзалт болж Declaration of Istanbul буюу Станбулын тунхаглал баталсан. Энэ нь эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээний үед хүний наймаа, хүний эс, эд, эрхтний наймаа, эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээний туризмын эсрэг хамтран ажиллах тунхаглалд гарын үсэг зурцгаасан юм. Монгол улс энэхүү тунхаглалд 2018 онд Испани улсад болсон дэлхийн эрхтэн шилжүүлэн суулгах нийгэмлэгийн 27 дугаар их хурлын үеэр элсэн орсон.

Түүнчлэн Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын (ДЭМБ) 2010 оны 5 дугаар сард хуралдсан 63 дугаар чуулганаар “Resolution WHO 63.22” шийдвэрийг баталсан. (Resolution WHA 75 Apr 2022 шинэчлэгдэн батлагдсан) Үүнд эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээ үйлчилгээ хийж буй улс орнуудад хандан ДЭМБ-аас эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээний үед баримтлах ерөнхий зарчим заавар гаргаж өгсөн. Энэ нь нийт 11 ерөнхий зарчимтай бөгөөд аливаа улс орон өөрийн орны хууль дүрэм, журамд эдгээр зарчмуудыг тусган үйл ажиллагаандaa мөрдлөг болгон ажилладаг. Манай улсын одоо хэрэгжиж буй “Донорын тухай” хууль болон бидний боловсруулж буй “Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай” хууль нь эдгээр зарчимд үндэслэн боловсруулагдаж байгаа болно.

Энэхүү зарчмуудыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2010 онд Испани улсын Мадрид хотноо “The Madrid Resolution Self-Sufficiency” зарчмыг баталса. Энэ нь эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээ үйлчилгээ хийж буй аливаа орон юуны түрүүнд донорын эрхтэн, эд, эсээр өөрийн орны хэрэгцээг хангах тухай зөвлөмж юм. Энэ нь эрхтэн, эд, эсийг өөр орон руу дамжуулах, худалдан наймаалцах үйл ажиллагааг хязгаарлахтай холбоотой зохицуулалт болно. Гэхдээ улс орнуудын хооронд эрхтэн хуваарилалт (OrganSharing) хийдэг хамтарсан тогтолцоонууд байдаг.

Эдгээр бодлогын баримт бичгүүдүн үзэл баримтлал, хэрэгжилтийг хангах үүднээс “Донорын тухай” хуулийг баталсан бөгөөд цаашлаад эрхтэн, эд, эс

шилжүүлэн суулгах эмчилгээ үйлчилгээ нь хуулийн хүрээнд явагдах, иргэдэд дэлхийн жишигт нийцсэн эмчилгээ үйлчилгээг хүргэхтэй холбоотой асуудлыг зохицуулах эрх зүйн баримт бичгийг хуульчлан батлах хэрэгцээ байна. Тус хуульд эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээтэй холбоотой нарийн төвөгтэй, мэргэжлийн онцлог бүхий асуудлуудыг дэс дараалалтай шийдвэрлэж байх зарчмыг баримталж хуулийн төслийг боловсруулахаар Эрүүл мэндийн сайдын тушаалаар мэргэжил бүрээс бүрдсэн ажлын хэсэг байгуулагдан ажилласан билээ. Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээ үйлчилгээ нь биеэ даасан тус тусдаа хөгжин, өргөжин тэлж байгаа салбарууд бөгөөд энэ хуулинд тус тусдаа тусгай бүлэг болон орохоор төлөвлөгдсөн болно.

### **Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа,хамрах хүрээ**

Хуулийн төслийн зорилго нь нь хүний эрүүл мэндийг хамгаалах, амьдралын чанарыг сайжруулах зорилгоор сайн дураараа эрхтэн, эд, эсээ үнэ төлбөргүй өгөх, шилжүүлэн суулгах цогц үйл ажиллагаа, зохион байгуулалт, эрх зүйн үндсийг тогтооход оршино.

Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тусламж үйлчилгээний эрх зүйн орчинг боловсронгуй болгох, эмчилгээг тэгш, хүртээмжтэй, үнэн шудрага байх зарчмыг баримтлан ажиллах, эмчилгээ үйлчилгээний шинэ арга технологи нэвтрүүлэх, илүү хурдацтай хөгжих боломж нөхцлийг бүрдүүлэх эрх зүйн орчинг тусгаж өгнө. Түүнчлэн Ёс зүйн хороо байгуулах, нэгдсэн бүртгэл мэдээллийн сан байгуулан ажиллуулах, доноорт олгох санхүүгийн болон бусад дэмжлэг, туслалцааг тодорхой болгох, хүүхдэд эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах зардлыг төр хариуцах, эрүүл мэндийн байгууллага бүрт амьгүй доноороос эрхтний донорын үйл ажиллагааг дэмжин ажилладаг тогтолцоог бий болгох талаар зохицуулсан. Монгол улсын эрүүл мэндийн салбарт эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах болон донор эмнэлгүүдийн хоорондын хамтын үйл ажиллагааг дэмжих, чадавхийг сайжруулах, улам боловсронгуй болгох, тус салбарын эмч, ажилчдын цалин хөлс, урамшуулал хийгээд салбарын тогтвортой хөгжил, хэрэгцээт тоног төхөөрөмж багаж, хэрэгсэлийн хангарт, туршилт, судалгаа, тасралтгүй сургалт, тогтвортой санхүүжүүлт зэрэг харилцаануудыг зохицуулахад оршино.

Хуулийн төсөл дараах бүтэцтэй байна.

1. Хуулийн төслийн нэгдүгээр бүлэгт хуулийн зорилго, хууль тогтоомж, хуулийн үйлчлэх хүрээ, хуульд тодорхойлогдох шаардлагатай нэр томъёоны тодорхойлолт болон үйл ажиллагаанд баримтлах зарчмыг тодорхойлно.
2. Хуулийн төслийн хоёрдугаар бүлэгт реципиент болон амьд донорыг сонгох, тэдгээрийн эрх үүрэг, амьгүй донорыг илрүүлэх, бүртгэх болон тавигдах шаардлагын талаар тусгана.
3. Хуулийн гуравдугаар бүлэгт эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тусламж үйлчилгээтэй холбоотой эрх зүйн асуудлуудыг тусгах ба эрхтэн, эд, эс авах,

шинжлэх, боловсруулах, хадгалах, тээвэрлэх, устгахтай холбоотой үйл ажиллагаанд баримтлах зарчмыг тусгана.

4. Хуулийн дөрөвдүгээр бүлэгт эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах үйл ажиллагааны удирдлага, бүтэц, зохион байгуулалтын талаар тусгана. Уг үйл ажиллагааг зохион байгуулах удирдлагын тогтолцоог тодорхойлж, Монгол Улсын засгийн газар болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрхийг тусгана. Мөн эрхтэн эд, эс шилжүүлэн суулгах асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага болон эрүүл мэндийн байгууллагын нийтлэг чиг үүргийг тусгана.

5. Хуулийн тавдугаар бүлэгт бусад зүйл, санхүүгийн тогтолцоо, хяналтын тогтолцооны талаар тусгана.

**Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар**

1. Одоогоор бүрэн зохицуулагдаагүй байгаа эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээний харилцаа бүрэн зохицуулагдах эрх зүйн орчин бүрдэнэ.
2. Хуулийн төсөл батлагдсанаар эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тусlamж үйлчилгээний хүрээ нэмэгдэж, гадагш явж тусlamж үйлчилгээ авч буй иргэдийн тоо буурч, эх орондоо дэлхийн жишигт хүрсэн эмчилгээ үйлчилгээг авах боломж илүү болж, иргэдийн амьд явах, эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусlamж авах эрх хангагдана.
3. Хуулийн төсөл батлагдсантай холбоотой улсын төсөв, санхүүгийн нэмэлт зардал богино хугацаандаа гарах боловч урт хугацаандаа эх орондоо чанартай, хүртээмжтэй дэлхийн жишигт хүрсэн эмчилгээний тусlamж үйлчилгээ нэмэгдэж гадагш гарах олон сая валютыг хэмнэх боломж бүрдэнэ.
4. Хүйн цус, эс, эдийн сан байгуулагдснаар одоо эмчилэх боломжгүй байгаа олон төрлийн өвчнийг эмчлэх боломжийг хангахад том алхам болно.
5. Амьгүй доноороос эд, эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээ үйлчилгээ нэмэгдэж, амьд донорыг хамгаалах үйл явц сайжирна. Хүний наймаа болон хүний эрхтний наймаанаас сэргийлэх нөхцөл улам сайжирна.
6. Төр даах тусlamж үйлчилгээнд хүүхдэд эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах зардлыг оруулан тооцсоноор эрүүл мэндийн даатгалын сангаас олгох санхүүжилтын зөрүүг төр даах бөгөөд жилд эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тоо цөөн тул хуулийн төслийг батлан хэрэгжүүлэхэд улсын төсөвт төдийлөн ачаалал үүсгэхгүй.

7. Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээ үйлчилгээний шаардлагатай багаж хэрэглэл, тоног төхөөрөмж, шинжилгээ судалгаа, сургалтын үйл ажиллагааны санхүүжилтийн шинэ тогтолцоог бий болгоно.
8. Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээний хэрэгцээ шаардлага улам их болж буй бөгөөд үүнтэй холбоотойгоор эмчилгээ, үйлчилгээний тоо, хүртээмжийг нэмэгдүүлэх шаардлага үснэ. Энэ нь эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах төрийн захиргааны байгууллага байгуулах нь зайлшгүй болохыг илтгэж байна.
9. Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээний тусламж үйлчилгээг нэг дор үзүүлж байгаа улс орон цөөн байгаа бөгөөд манай орон шиг хөгжиж буй орнууд эдгээр эмчилгээг нэгэн зэрэг хийх боломжгүй байгаа нь Монгол улын эрүүл мэндийн салбарын нэр хүнд, эзлэх байр суурийг тодорхой өндөр түвшинд байгааг илтгэж байдаг.

**Дөрөв. Хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, түүнийг хэрэгжүүлэх зорилгоор цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаар**

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хуульд нийцсэн, бусад хуультай нийцсэн байх бөгөөд уг хуулийн төсөлтэй холбогдуулан Эрүүл мэндийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай, Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хууль болон Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хуулийн дагаж мөрдөх журамд нэмэлт өөрчлөлт оруулж, Донорын тухай хууль хүчингүй болох бөгөөд ул хуулийг дагаж гарсан журмууд өөрчлөгдөн дахин боловсруулагдана.

---оОо---